

ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ
Оюу Толгойд олгох шинэ зээллэгэд нөхцөл суулгахыг
ЕСБХБ ба ОУСК-д шаардах нь

2024 оны 12 сар

Энд гарын үсэг зурсан иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ууд болон Монголын малчдын төлөөлөл бид, Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК) ба Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-аас Оюу Толгой (ОТ)-д тус бүр 100 сая ам. долларын зээл олгох шийдвэрийг эрс буруушааж байна. Энэхүү шийдвэр нь олон жилийн турш барагдуулаагүй гомдол, байгаль орчны хор хөнөөл, ОУСК ба ЕСБХБ-ны хамгааллын стандартад нийцүүлж мөрдөөгүй болон нутгийн малчид, ИНБ-ууд, тэр байтугай Монголын засгийн газар зэрэг өргөн хүрээ бүхий эсэргүүцлийг илт үл тоомсорлож байна.

Шийдвэрлээгүй хор хөнөөл ба үл нийцэл

Оюу Толгой нь 2017 оны Малчдын гомдлыг барагдуулах гэрээгээр хүлээсэн үүрэг амлалт, ОУСК ба ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн хамгаалал зэрэг чухал асуудлуудыг шийдээгүй. Он удаан жил шийдээгүй асуудлууд нь:

- 1. Гомдол барагдуулах гэрээг хэрэгжүүлээгүй байдал:** ОУСК-ийн Омбудсманы газарт гаргасан гомдлын дүнд байгуулсан гэрээний хэрэгжилт дутуу дулимаг байгаагаас малчид амьжиргаагаа залгуулж, байгаль орчноо хамгаалахын төлөө тэмцсээр байна. 2017 оны Гэрээг хэрэгжүүлэх үүрэг бүхий Гурван талт зөвлөл (ГТЗ)-өөс малчдын эрх ашгийг хамгаалах, амьжиргааг хамгаалахад бодитой оролцоог хангаж чадаагүй.
- 2. Хаягдлыг хадгалах байгууламж (ХХБ)-ийн шүүрэл:** Сэргээн засах үйл ажиллагааны төлөвлөгөө (RAP) хэрэгжүүлж байгаа хэдий ч ОТ шүүрлийг багасгаагүй, түүний цар хүрээг бүрэн гүйцэд ил тод зарлаагүй байна. Сүүлийн үеийн мэдээллээс үзэхэд усны чанар муудаж, нийт ууссан хатуу бодисын (TDS) түвшин доод урсгалд огцом нэмэгдэж байна.
- 3. Бэлчээр, усны хомсдол:** Уурхайн өргөтгөлийн төлөвлөгөө нь амин чухал бэлчээр, усны нөөцөд аюул учруулж байна. Нэгэн цагт малчдын амьжиргааг тэтгэж байсан булаг шанд ширгэж, малчдыг хязгаарлагдмал нөөцийн төлөө өрсөлдөхөд хүргэжээ. Түүгээр барахгүй, малчдын усны гол эх үүсвэр болох Дугат-Халив голын гольдролыг ТС2 орчмоор шилжүүлж, борооны үеэр үерийн урсацыг дамжуулах чадваргүй шугам тавьсан нь голын доод хэсгийн малчдад очих ихээхэн хэмжээний ус алдагдахад хүргэсэн.
- 4. Байгаль орчны доголдол:** ОТ нь 64%-ийн хатуу агууламжтай байх хаягдлын дизайны зорилтод нийцүүлж чадаагүй ирснээр хаягдлын далан нь их хэмжээний илүүдэл усны даралтаар шүүрсээр ирсэн. Энэ болон бусад дизайны үр ашиггүй байдал нь жилд 1.46 сая доллараар хэмжигдэх их хэмжээний усны алдагдалд хүргэдэг.
- 5. Нутгийнхантай зохистой зөвлөлдөөгүй:** ОУСК болон ЕСБХБ-ны ил тод байдал, оролцооны зарчмуудыг зөрчиж, ХХБ-ийн шүүрлийн сөрөг нөлөөг Сэргээн

засварлах төлөвлөгөө болон ОТ-н өргөтгөлийн төлөвлөгөөний талаар малчидтай утга учиртай зөвлөлдөөгүй.

Усны буруу менежмент ба үрэлгэн байдал

ОТ-йн үйл ажиллагаа нь хаягдлын далангийн менежментийн үр ашиггүй байдлаас усны хомсдлыг хурцатгаж байна. Хаягдал лагын хатуу агууламж нь дизайны зорилтот стандартад хүрээгүйгээс ус дэмий үрж байгаа нь санхүүгийн болон байгаль орчны ихээхэн зардалд хүргэдэг. Үүнд:

- 2013-2017 онуудад ОТ хатуу бодисын 56% (дизайн стандартаас 8%-иар дутуу)¹-тай хаягдал лаг гаргаж, жил бүр 1.46 сая долларын усыг дэмий үрсэн. 2018-2024 онуудад ОТ нь дунджаар 60%-иар хатуу агууламжтай (дизайн стандартаас 4%-иар дутуу) хаягдалд хүргэсэн нь ОТ-оос үргүй хаясан усыг орлуулахад² жил бүр 730,000 доллар зарцуулдаг гэсэн үг. ОТ компани 2017 оноос хойш 248.2 сая литр ус алдсанаас болж ойролцоогоор 12.41 сая долларыг дэмий үрсэн байна³.

- Өмнийн говийн усны хомсдлоос урьдчилан сэргийлэх, малчдын усны хүртээмжийг сайжруулахын тулд Оюу Толгой (ОТ) нь дизайны шалгуурт заасан хатуу агууламжийн харьцааг хамгийн өндөр хувь буюу 64%-д хүрэх ёстой. Зээлдүүлэгчид 60-64%-ийн хүрээ нь стандартын шаардлага хангасан гэж маргадаг бол 60%-иас доош үзүүлэлттэй тогтмол ажиллах нь усны хэт их хаягдал үүсгэж, говийн эмзэг экосистем болон цэвэр усны хязгаарлагдмал нөөцөд тулгуурласан малчдын амьжиргаанд ноцтой эрсдэл учруулдаг. Зорилтот 64%-д хүргэх нь зүгээр нэг сонголт биш, байгаль орчинд учруулах хор хөнөөлийг багасгах, нөөцийн ашиглалтыг оновчтой болгох зайлшгүй шаардлага бөгөөд ОТ-н орон нутгийн иргэдийн өмнө хүлээх үүрэг юм.

- Энэхүү үр ашиггүй байдал нь хаягдлын далангийн бүтцийн сул талыг улам бүр нэмэгдүүлж, өндөр өртөгтэй дахин төлөвлөлт хийхэд хүргэж, сүйрлийн эрсдэлийг нэмэгдүүлсээр байна⁴.

Төслийн ангилал ба улс төрийн эрсдэлт асуудлууд

¹ Multi-disciplinary Team and Independent Expert Panel Joint Fact Finding Report, January 2017, p.207. OT's response to Accountability Counsel's Commentaries on TSF Remedial Action Plan dated 9 July 2024, annex 1.

² Discussion held during OT Water Efficiency Workshop, September 2024. 0.51 USD is a rough estimate of the cost of one cubic meter of water from the Gunii Hooloi Aquifer. Using 0.50 USD for calculation, 1 tonne of water = 1,000 liters = 1 cubic meter = 0.50 USD. 1,000 ton/day = 500.00 USD per day to replace from Gunii Hooloi = 1% excess water in tailings. 1,000 x 365 days x 0.50 = \$182,000 per year is the replacement cost of the water wasted to tailings for each per cent below the design goal of 64%.

³ Under the assumption that 2013–2017 (5 years at 56% solids) = \$1.46M annually × 5; 2018–2024 (7 years at 60% solids) = \$730,000 annually × 7.

⁴ The September 2024 Water Efficiency Workshop recommends OT to install a third thickener to solidify the tailings content in and dewater the TC1.

ОУСК болон ЕСБХБ малчид болон байгаль орчинд асар их, эргэлт буцалтгүй нөлөөлөл үзүүлж байгаа ОТ-н энэ зээлийн төслийг эрсдлийн **В Ангилал** гэж ангилсанд бид ихэд санаа зовж байна. Энэхүү буруу ангилал нь эрсдлийн цар хүрээг багасгаж, зохих хяналтыг алдагдуулдаг. Үүний зэрэгцээ, Монгол Улсын Засгийн газар нэмэлт санхүүжилтийн талаар санал зөрөлдөж, далд уурхайн зардлын хэтрэлтэд хөндлөнгийн аудит хийхийг⁵ шаардсан ч компаниуд шаардлагатай баримт мэдээллийг хөндлөнгийн эксдертүүдэд гаргаж өгөөгүй⁶. Улс төр, нийгмийн ийм маргаантай нөхцөлд шинэ санхүүжилтийг батлах нь төслийн хэрэгжилтэд ихээхэн эрсдэл учруулна.

Зөвлөмж ба нөхцөл болзлууд

ОУСК болон ЕСБХБ нь аливаа санхүүжилт эхлэхээс өмнө ОТ-д хатуу болзол тавьж, зээлийн гэрээнд дараах нөхцөлүүдийг тусгах шаардлагатай байна. Үүнд:

1. Өмнөх амлалтаа биелүүлэх:

- Зээлдүүлэгчдийн нийцүүлэх стандартад 2017 оны Малчдын гомдлыг барагдуулах гэрээг (МГБГ) тусгаж, бүрэн хэрэгжүүлэх.
- ХХБ-ийн шүүрлээс үүдэлтэй бохирдсон усанд нэрвэгдсэн малчид болон тэдний малын эрүүл мэндийн тогтмол үзлэгийг оруулах болон Сэргээн засварлах ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, шүүрлийн нөлөөнд өртсөн малчдын өргөн хүрээг хамруулах үүднээс Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг шинэчлэх.

2. Ус ба хаягдлын менежментийг сайжруулах:

- Анхны БОННУ-ний дагуу хаягдлын хатуу агууламжийн 65%-ийн зорилтод хэмжээнд хүргэх.
- Химийн бохирдол, эрүүл мэндийн эрсдэл зэрэг ХХБ-ийн шүүрлийн нөлөөллийг бүрэн хэмжээгээр ил тод болгох

3. Малчдын амьжиргааг хамгаалах:

- Малчдыг нүүлгэн шилжүүлэх газар чөлөөлөлтийг бүрмөсөн зогсоож, одоо байгаа лицензийн талбайдаа ирээдүйн хаягдлын далан байгуулахыг зорилго болгох.
- Хамгийн их үерийн тулгуурлан Халив-Дугатын байнгын чиглүүлэгч суваг барих.

4. Ил тод байдал ба утга учиртай оролцоо:

- Өргөтгөх төлөвлөгөө, ОТ төслийн анхны зээлээс эхлэн БОННУ-ийн хэрэгжилт, ОТ Ногоон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бүх үнэлгээг (БОННУ) ил тод болгох

⁵ Parliament Resolution #103 dated 30 December 2021 point 4 states “The foreign investor shall bear 100 percent of the additional expenses until the underground mine of the Oyu Tolgoi project is put into operation and mining production begins, i.e. until the first half of 2023, and Erdenes Oyu Tolgoi LLC shall not incur additional debt; Oyu Tolgoi LLC shall not receive additional financing from shareholders and other third parties. <https://www.parliament.mn/files/30942275a3b44d5cb92fc3379a5bb888/?d=0>

⁶ <https://soyolon.mn/?p=2016&lang=en>

о Нөлөөлөлд өртсөн/өртөх бүлгүүдтэй төслийн бүх асуудлаар утга учиртай зөвлөлдөхийг баталгаажуулах. Үүнд, ОТ төслийн эргэн тойронд малчдын тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий байгууллага болох Гурван талт зөвлөлийг малчдын бодит төлөөллөөр бэхжүүлэх болон өргөтгөлийн төлөвлөгөө, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой бүх баримт бичгүүдийн талаар зөвлөлдөх зэрэг багтана.

Эдгээр чухал асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр ОТ-д шинээр санхүүжилт олгох нь малчид болон байгаль орчинд хор хөнөөл учруулахын зэрэгцээ ОУСК ба ЕСБХБ-ны тогтвортой хөгжлийн амлалтад итгэх олон нийтийн итгэлийг бууруулж байна. **Бид ОУСК болон ЕСБХБ-ыг байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлогоо сахиж, Оюу Толгой үйл ажиллагаагаа тэдгээрт бүрэн нийцүүлж, малчид болон байгаль орчны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх хүртэл гэрээнд гарын үсэг зурах, санхүүжилтийг олгох явдлыг түдгэлзүүлэхийг уриалж байна.**

Signatories:

1. Gobi Soil, Mongolia
2. Oyu Tolgoi Watch, Mongolia
3. Center for Human Rights and Development, Mongolia
4. Accountability Counsel
5. CEE Bankwatch Network, Regional
6. AFE, Mongolia
7. London Mining Network
8. Witness Radio, Uganda
9. Both ENDS, the Netherlands
10. INWOLAG
11. LSD, Senegal
12. RwB Mongolia
13. Friends with Environment in Development (FED), Uganda
14. MFSW - Mongolia
15. Green Advocates
16. Gender Action - USA
17. Peace Point Development Foundation-PDF - Nigeria
18. GAIA - Asia Pacific
19. CA NGO, Mongolia
20. GFS, Mongolia
21. International Accountability Project
22. NGO Forum on ADB - Regional
23. Recourse
24. Bank Information Center - USA
25. Urgewald - Germany
26. Earth Thrive UK/Serbia
27. Initiative for Right View (IRV), Bangladesh
28. APPDO, Mongolia

29. SR NGO, Mongolia
30. Kazakhstan International bureau for human rights - Kazakhstan
31. Centre for Research and Advocacy, Manipur - India
32. SWB NGO - Mongolia
33. Sinergia Animal - Brazil
34. SWA - Mongolia
35. Bank Climate Advocates - USA
36. Center for Community Mobilization and Support, Armenia
37. Samata & mm&P - India